



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 07 сарын 26 өдөр

Дугаар 224

Улаанбаатар хот

Г “Бэрх-Уул” ХК-ийн нэгдмэл сонирхолтой 7
хувьцаа эзэмшигчдээс гаргасан тендер саналыг
зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 58.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Бэрх-Уул” ХК-ийн нийт гаргасан 19,062,080 ширхэг энгийн хувьцааны 99.88 хувь буюу 19,039,047 ширхэг хувьцааг нэгдмэл сонирхолтойгоор эзэмшигч “Файрбөрд Глобал Мастер Фанд” ХХК, “Файрбөрд Глобал Мастер Фанд II” ХХК, “Файрбөрд Монголиа Фанд” ХХК, “Хэнэте Ресурси Холдинг Эс.Эй.Пи.Эл” ХХК, “Вью Холдинг Эс.Эй.Пи.Эл” ХХК-иудаас тус хувьцаат компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 0.12 хувь буюу 23,033 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 392 /гурван зуун ерэн хоёр/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авч тус компанийг 100 хувь эзэмшихээр тендер санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2011 оны 7 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоногоор тогтоосугай.

2. Холбогдох хууль, журмын дагуу тендер саналаа нийтэд сурталчилж, хуулиар хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэхийг “Файрбөрд Глобал Мастер Фанд” ХХК, “Файрбөрд Глобал Мастер Фанд II” ХХК, “Файрбөрд Монголиа Фанд” ХХК, “Хэнэте Ресурси Холдинг Эс.Эй.Пи.Эл” ХХК, “Вью Холдинг Эс.Эй.Пи.Эл” ХХК-иудад тус тус үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /С.Тулгаа/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН